



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН  
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ**

2014 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 22

Шарга

┌ Загас агнуурын бүс тогтоох тухай ┐

Амьтны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын "Заавар үлгэрчилсэн дүрэм батлах тухай" 2013 оны А-331 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах заавар"-ын 1.3, Сумын ерөнхий агнуур зохион байгуулалтын тайлан, менежментийн төлөвлөгөөг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1. Дэлгэрмөрөн голын голдирлын дагуу Цагаан-Уул сумын нутаг дэвсгэрт хамаарах Цагаан булангаас Улаан үзүүр /49°58'9.70"N 98°50'60.00"E-ээс 49°35'11.95"N 99°11'38.00"E/ хүртэлх газар нутгийг ахуйн болон тусгай зориулалтаар загасчлах бүсээр тогтоон баталсугай.

2. Загас агнуурын бүсээр батлагдсан газар нутгийн тойм зургийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

3. Ахуйн болон тусгай зориулалтаар загас агнах, барих зөвшөөрлийг зөвхөн агнуурын бүс нутгаас олгож, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга /Д.Түмэнбаяр/, Байгаль орчны хяналтын улсын байцаагч /Г.Одгэрэл/ нарт тус тус даалгасугай.

ДАРГА  Ч.АЗБАЯР



00038

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2014 оны 06 сарын 04-ний  
22 дугаар тогтоолын 1 дугаар Хавсралт



49°58'9.70"N 98°50'50.00"E

49°35'11.95"N 99°11'38.00"E

Image © 2014 Earthstar  
Image Landsat  
© 2014 Google

Google earth

Imagery Date: 4/10/2013 49°44'59.55"N 99°05'23.09"E elev 1051 m eye alt 62.22 km